

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 10 ДУГААР 03-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 10 дугаар сарын 13

Улаанбаатар хот

д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг сар болгон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байгаатай холбогдуулан хэрэгжилт нь удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлж, байгууллагууд цаг хугацаанд тайлагнаж ажиллах. /Нийт байгууллагууд/				
1.	Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан дүүрэгт хамааралтай Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 1 арга хэмжээ, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 3 арга хэмжээ, нийт 4 арга хэмжээний биелэлтийг нэгтгэн 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд, нийслэл хариуцан гүйцэтгэх зорилтын хэрэгжилт, үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд /ERP/ хүргүүлсэн.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
Үүрэг, даалгавар-ХОЁР: 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын гүйцэтгэл, үр дүнг энэ 7 хоногийн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах./ Захирагчийн ажлын алба Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлагууд, Инженер хангамжийн байгууллагууд/				
2.	Нийслэлийн Засаг даргын А/853 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган дүүргийн Засаг даргын 2022 оны А/253 дугаар захирамжаар 55 хүний бүрэлдэхүүнтэй өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулагдан, дүүргийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 12 салбар 118 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 2022 оны 10 дугаар сарын байдлаар 94,2% -тай байна. Үүнд: 1. Нийтлэг үйлчилгээний газар -95% 2. Боловсролын хэлтэс – 95% 3. Онцгой байдлын хэлтэс – 95% 4. Эрүүл мэндийн төв – 90% 5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв – 100%	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

	<p>6. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6 -89%</p> <p>7. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7 -75%</p> <p>8. “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК -100%</p> <p>9. “Найши трейд” ХХК -100%</p> <p>10. “Соёндрийм” ХХК -92%</p> <p>Хувийн халаалтын уурын зуухнууд:</p> <p>11. Ану сервис” ХХК -100%</p> <p>12. “Элбэг дулаан” ХХК -100% гүйцэтгэлтэй байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Зөвлөлийн хуралдаанд дүүргийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц, мэдээг дүүргийн Засаг даргын орлогч дарга танилцуулан ажилласан.</p>			
<p>Үүрэг, даалгавар ГУРАВ: Хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа автозам, тохижилт, инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлийн ажлуудыг дуусгаж, ухсан нүх, эвдэрч гэмтсэн авто зам, явган зам талбайг нөхөн сэргээх, засварлах ажлаа чанартай гүйцэтгэж хэрэгжилтэд хяналт тавих. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлагууд, Инженер хангамжийн байгууллагууд/</p>				
3.	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 төсөл арга хэмжээ хэрэгжихээс:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Комисс хүлээн авсан-8 төсөл арга хэмжээ, ✓ Он дамжин хийгдэх 3 төсөл арга хэмжээ, ✓ Бэлтгэл ажлын шатандаа 2 төсөл арга хэмжээ, ✓ 2022 онд дуусгахаар 1 төсөл арга хэмжээ байна. <p>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13 төсөл арга хэмжээ хэрэгжихээс:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Комисс хүлээн авсан-6 төсөл арга хэмжээ, ✓ Он дамжин хийгдэх 4 төсөл арга хэмжээ, ✓ Бэлтгэл ажлын шатандаа 2 төсөл арга хэмжээ, ✓ 2022 онд дуусгахаар 1 төсөл арга хэмжээ байна. <p>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээ хэрэгжихээс:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Комисс хүлээн авсан-1 төсөл арга хэмжээ, ✓ Бэлтгэл ажлын шатандаа 2 төсөл арга хэмжээ, <p>Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8 төсөл арга хэмжээ хэрэгжихээс:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Комисс хүлээн авсан-5 төсөл арга хэмжээ, ✓ Бэлтгэл ажлын шатандаа 3 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. <p>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 18 төсөл арга хэмжээ хэрэгжихээс:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Комисс хүлээн авсан-16 төсөл арга хэмжээ, ✓ Бэлтгэл ажлын шатандаа 1 төсөл арга хэмжээ, ✓ 2022 онд дуусгахаар 1 төсөл арга хэмжээ байна. <p>Дүүргийн 13, 16, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт дэх чулуун замын засварын ажлыг дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК гүйцэтгэн бүрэн дууссан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70

Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэг нэмэгдүүлэх ажлаа эрчимжүүлж, борлуулалтын цэгүүдийг сайжруулсан түлшээр тасалдуулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авах, авто тээврийн шалган бүртгэх товчоодын хяналтыг сайжруулах. /Агаарын бохирдолтой тэмцэх газар, Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар, "Таван толгой түлш" ХХК /

4.	<p>Дүүргийн хэмжээнд 2021-2022 оны өвөлжилтийн жилд үйл ажиллагаагаа 100 хувь үнэлүүлсэн нийт 78 сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын цэгийг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн гэрээ байгуулан үйл ажиллагааг бүрэн нээсэн. Шинээр 22 сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын цэгийг 2022-2023 оны халаалтын улиралд нээхээр тайлан, мэдээг Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газарт хүргүүлээд байна.</p> <p>Дүүргийн хэмжээнд нийт 8 агуулах, 4 саравчинд нийт 12892,5 тн сайжруулсан шахмал түлш нөөцөлсөн. Сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын цэгүүд өдөрт дунджаар 5 тн түлшний татан авалтыг тогтмол хийн ажиллаж байна.</p> <p>Дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Гүнтийн байнгын постонд 24 цагаар 2 алба хаагч тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Байнгын постоор дамжин өнгөрсөн нийт 4564 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийснээс нийт зөрчил гаргасан 2,565 тээврийн хэрэгсэл байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Цагдаагийн байгууллагын нийтлэг үүргээр-25, ➢ Асап сангаар эргэн сурвалжлагдаж байсан этгээд-10, ➢ Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 2530 жолоочид 29,500,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. 	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
----	--	---	---------------------------------------	----

Үүрэг, даалгавар ТАВ: 9 дүгээр сарын орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд хангаж, орлогын тасалдлыг нөхөж, гүйцэтгэлийг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. /Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Татварын газар, Өмчийн харилцааны газар, Газар зохион байгуулалтын алба, Замын цагдаагийн газар, бусад байгууллагууд/

5.	<p>Дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөө 2022 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 101,096,960 мянган төгрөг, гүйцэтгэл 95,607,425 мянган төгрөг буюу 94%-тай байна. Дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөө 9 дүгээр сард 15,558,389 мянган төгрөг байхаас 11,669,517 мянган төгрөг төвлөрүүлж, гүйцэтгэл 75%-ийн гүйцэтгэлтэй байна. Дүүргийн төсвөөс Нийслэлийн төсөвт 60,665,209.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 55,043,254.8 мянган төгрөг төвлөрүүлж, 90,7%-ийн биелэлттэй байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
----	---	---	---------------------------------------	----

Үүрэг, даалгавар ЗУРГАА: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлж, төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах, үргүй зардлыг багасгаж, нийслэлийн өмчийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч, хэрэгжилтэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс тогтмол хяналт тавьж ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон нийт байгууллагууд/

6.	<p>Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2022 оны "Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах" тухай А/45 дугаар захирамжийг 2022 оны 4/246 тоот албан бичгээр, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтийг хангаж ажиллахыг 4/1596 тоот албан бичгээр, төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дүүргийн Засаг даргын 2022 оны 1/1745 тоот албан бичгээр харьяа 69 байгууллагын төсвийн шууд захирагч нарт тус тус хүргүүлж, өдөр</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
----	--	---	---------------------------------------	----

	<p>тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан. Өмчийн эд, хөрөнгийн улсын үзлэг тооллогоор дүүргийн харьяа хэлтэс, алба, төр захиргааны байгууллага 17, Цэцэрлэг 39, сургууль 18, өрхийн эрүүл мэндийн төв 16 нийт 90 байгууллага хамрагдахаас 100% хамрагдаж дууссан.</p> <p>Улс, нийслэл орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 23 төрлийн 2,182,976,862 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг байгууллагын даргын тушаалаар бүртгэн авсан. Дүүргийн засаг даргын 2020 оны А/473 дугаартай захирамжаар томилогдсон Ажлын хэсэг Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 61 ажлыг хүлээн авч байнгын ашиглалтад оруулсан ба холбогдох материалын бүрдлийг хангуулан хүлээж авч гэрээг дүгнэн ажилласан.</p>			
<p>Үүрэг, даалгавар ДОЛОО: Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын удирдлагууд өөрсдөө салбар салбарын хэмжээнд хийгдэж байгаа ажлуудынхаа гүйцэтгэл, үр дүнг, тоон мэдээлэл, судалгааг иргэд, олон нийтэд мэдээлэх. /Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын удирдлагууд/</p>				
7.	<p>Дүүргийн Засаг дарга болон дүүргийн холбогдох удирдах албан тушаалтнууд улс, нийслэл, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, боловсрол, эрүүл мэндийн салбарт хийгдэж буй ажлуудын гүйцэтгэл, үр дүнг танилцуулах зорилгоор дүүргийн 7, 12, 13, 14, 16, 17, 19, 20, 24 дүгээр хороодын 1524 иргэдтэй уулзалт зохион байгуулан ажиллалаа.</p> <p>Уг уулзалтад Нийслэл, дүүргээс сонгогдсон Иргэдийн төлөөлөгчдийн гишүүд болон дүүргийн Газар зохион байгуулалтын алба, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Боловсролын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХК, ЧДХҮТ, Соёндрийн” ХХК-ний удирдлагууд оролцсон.</p> <p>Тус уулзалтаар иргэдийн зүгээс амьдрах орчныг сайжруулах, явган хүний зам талбайн тохижилт цэвэрлэгээ, Хууль зөрчсөн газар олголтын асуудлыг шийдвэрлэх, газар эзэмших болон өмчлөх эрхийн гэрчилгээ гаргуулах, 0,7 га газрыг эзэмшүүлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлэх зэрэг давхардсан тоогоор 180 гаруй иргэдийн санал хүсэлт, асуудлыг сонсож, холбогдох хэлтэст уламжлан, эрчим хүч, цахилгаан дулаан, гэрэлтүүлэгтэй холбоотой гомдол саналуудыг газар дээр нь шийдвэрлэн ажилласан.</p>	=	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	100

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА М.НАВЧАА

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Х.ТУЯА